



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Г Орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн
газрын нэрийг өөрчилж, дурмийг батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 "ж", 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1."Улаанбаатар чуулга" орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн газрын нэрийг "Улаанбаатар театр" орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчилж, дурмийг хавсралтаар баталсугай.

2."Улаанбаатар театр" орон нутгийн өмчтэй төсөвт үйлдвэрийн газрын орон тооны хязгаарыг тогтоож, 2022 оны төсөвт тусгувж, тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумьяабазар/-т үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Б.Батбямбад/-д даалгасугай.



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тзргүүлэгчдийн 2021-оны 11
дугаар сарын 08-ны өдрийн дугаар
тогтоолын хөвсрэлт

"УЛААНБААТАР ТЕАТР" ОНӨТҮГ ҮНДСЭЛЭМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДСЭЛЭЛ

1.1."Улаанбаатар театр" ОНӨТҮГ (цаашид "Театр" гэх) нь Монгол Улсын Их Засгийн газраас соёл, урлагийн талаар баримтлах болдого, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас соёл, урлагийт дэмжих талаар гаргасан шийдвэр, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийслэлийн хэмжээнд зохион байгуулах, нийслэлийн хүн амд үзүүлэх соёл урлагийн олон талт үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн уран сайхны боловсролыг дээшүүлж, ардын болон сонгодог, орчин үеийн урлагараа үйлчлэх, бусад хайгууллага иргэдтэй харилцах хэм хэмжээг зохицуулахад энэхүү дүрмийг баримтална.

1.2. Театр нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Соёлын тухай хууль, Төсийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэр, энэ дүрмийг мөрдөж ажиллана.

1.3. Театр нь үйл ажиллагааныхаа явц, үр дүнг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө хариуцаж, тайлagnана.

1.4. Театр бие даасан хуулийн этгээд байх бөгөөд зохих журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж нийслэлийн Төрийн сан банканд данстай байна.

1.5. Театр нь "Мэргэжлийн урлагийн байгууллагын орчин нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага" МНС 6476:2014 стандартыг хэрэгжүүлж ажиллана.

ХОЁР. ТЕАТРЫН ҮНДСЭН ҮҮРЭГ

2.1. Театр нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Соёл урлагийт хөгжүүлэх талаар төрөөс баримталж байгаа болдого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг нийслэлийн хэмжээнд зохион байгуулна.

2.1.2. Нийслэлийн иргэдэд нийгмийн эрэлт хэрэгцээ шаардлагад нийцсэн соёл урлагийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх, соёл урлагийг хөгжүүлэх орчин, нөхцлийг бүрдүүлнэ.

2.1.3. Иргэдийн эрэлт хэрэгцээ, оюуны шаардлагад нийцсэн шинэ уран бүтээл түүрвих болон урын санд байгаа бүтээлийг сэргээх, хүүхдэд зориулсан уран бүтээл түүрвиж, үндэсний уламжлалт соёл, дэлхийн улс үндэстний урлагийг сурталчилж олон нийтийн хүртээл болгоно.

2.1.4.Үндсэн чиг үүрэгт харшлах, өөр зориулалтаар театрны эд хөрөнгийг бусдаад ашиглуулж, зээмшүүлэхийг хориглоно. Мөн өөрийн зээмшилд байгаа нийслэлийн өмчийг зориулалтын дагуу ашиглах, ашиглалтын байдалд хяналт тавих, хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авна.

2.1.5.Байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлаар ижил, төстэй гадаад, дотоодын байгууллагатай хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр байгуулан ажиллана.

2.1.6.Байгууллагын эд хөрөнгө, техник тоног төхөөрөмж, тоноглол, хувцас чимэглэл, дурс, гэрэл, дуу чимээний хэрэгслийн ашиглалтад хяналт тавьж сайжруулна.

2.1.7.Өөрийн урын сангийн шилдэг бүтээлээр хөдөө орон нутаг, алслагдсан дүүргийн иргэдэд жил бүр тогтмол үйлчилгээ үзүүлнэ.

2.1.8.Бусад зэрэглэлийн театр, чуулга, дүүргийн соёлын орднуудад мэргэжилт-арга зүйн туслалцаа үзүүлж, тэдгээрийн уран бүтээлч, ажилтны мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх сургалт-семинар зохион байгуулна.

2.1.9.Урлаг, театр судалалын чиглэлээр судалгааны ажил хийх, эрдэм шинжилгээний болон онол-практикийн хурал, семинар зохион байгуулж, энэ чиглэлийн ном, гарын авлага, заавар, зөвлөмжкөөр бусад зэрэглэлийн театр, чуулгыг хангана.

2.1.10.Судалгааны ажлын үр дүнгээ олон нийтийн хүртээл болгож, уран бүтээлдээ тусгах арга хэмжээ авна.

2.1.11.Нийслэлийн иргэдэд урлаг соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, түүний хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.1.12.Соёл урлагийн хөгжлийг тодорхойлох үндсэн болон хавсарга үзүүлэлтүүдээр статистикийн тоо, баримт, тайлан мэдээг нэгтэн боловсруулалт хийж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотыг Захирагч болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтанд танилцуулж байх;


2.1.13.Эрхэлсэн асуудлын хүрээнд ном, гарын авлага, зөвлөмж, эмхэтгэл, зурагт хуудас гаргах, сургалт явуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа, мэдээлэл хийх;

2.1.14.Соёл урлагийг хөгжүүлэх үйл хэрэгт тодорхой хувь нэмэр оруулсан байгууллага, хувь хүмүүсийг төр, засгийн болон нийслэлийн шагналаар шагнуулах талаар хүснэлт, тодорхойлолт гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

2.1.15. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох бусад байгууллагад эрхэлсэн асуудлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, холбогдох мэдээллийг шуурхай гаргаж өгөх;

2.1.16. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллах;

2.1.17. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийн хэрэгжүүлэх



ГУРАВ. ТЕАТРЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

3.1.Театрыг өөрчлөх, татан буулгах асуудлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиррагчийн саналыг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтооолоор шийдвэрлэнэ.

3.2.Театрын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч тогтооно.

3.3.Театр нь Хөдөлмөрийн тухай хуульд нийцүүлсэн хөдөлмөрийн харилцаа дотоод үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан байгууллагын дотоод журамтай байх бөгөөд журмыг хамт олны хурлаар хэлэлцэн баталж мөрднен.

3.4.Театрын өдөр тутмын үйл ажиллагааг Театрын дарга удирдана. Тус газрын даргыг хуулиар эрх олгосон албан тушаалтан чөлөөлж, томилно.

3.5.Театр нь гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй ажиллах бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар баттуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллана.

3.6.Театрын дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүрэг, уран бүтээл хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Захиргааны болон Уран сайхны зөвлөл байгуулан ажиллуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Театрын дарга батална.

3.7.Театрын даргын эзгүйд түүний эрх үүргийг тус газрын эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлж ажиллана.

3.8.Театрын дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.8.1.Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан нийт албан хаагчидтай Хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээ зөрчсөн албан хаагчдад холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулах;

3.8.2.Байгууллагын батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулах;

3.8.3.Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, заавар, дүрэм, журам баталж мөрдүүлэх;

3.8.4.Уран бүтээлчид болон албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах, мэргэжлийн албан хаагчийг нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр ажилд томилж, чөлөөлөх;

3.8.5.Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.8.6.Театрын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардлыг арилгах, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд холбогдох саналаа Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт уламжлах;

3.8.7.Байгууллагын дотоод журам, нийт албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ, эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажиллах;

3.8.8.Ажилтнуудын нийгмийн асуудлыг холбогдох хууль^{ИМТ} тогтоомж байгууллагын дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшшүүлэх, мэргшүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллах;

3.8.9. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захиргачийн шийдвэр, үүрэг даалгавар, хөтөлбөр, төслийг хэрэгкүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтэд хяналт тавих;

3.8.10. Хууль тогтоомж болон гэрзэгзэр олгосон бусад эрх, үргийг хэрэгжүүлнэ.

3.9. Театр нь төрийн захиргааны байгууллагуудтай Нийслэлийн Засаг даргаар дамжуулан харилцана.

ДӨРӨВСАНХҮҮГИЙН БОЛОН МАТЕРИАЛЛАГ НӨӨЦ

4.1. Театр нь Нийслэлийн төсвээс санхүүжих бөгөөд санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргана.

4.2. Театрын санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

4.4. Театрын орлого нь Нийслэлийн төсвийн санхүүжилт, ажил үйлчилгээнээс олсон орлого, хандивлагчдын тусламж, хууль тогтоомжкоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэрээс бурдэнэ.

4.4. Театрын дарга нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст тухайн жилийн үйл ажиллагаа, зарцуулсан хөрөнгө санхүүгийн тайланг бичгээр гаргана.

4.5. Театрын дарга, нягтлан бодогч нь Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт тухайн жилийн санхүүгийн тайланг хүргүүлж, үндсэн хөрөнгийн хөдөлгөөн өөрчлөлтийг хянуулна.

ТАВ. ТЕАТРЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ

5.1. Байгууллагын үндсэн хөрөнгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын зөвшөөрөлтэйгөөр захирсан зарцуулна.

5.2. Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дооод хяналтыг бүрдүүлж, бүртгэлээр тавих хяналтыг Нийслэлийн Засаг даргын өмнө театрын дарга, нягтлан бодогч нар хариузна.


5.3. Зориулалтын байр, тоног төхөөрөмжийг уран бүтээлийн үйл ажиллагаанд бүрэн ашиглана. Уран бүтээлийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор заалт, танхим, тайзыг мэргэжлийн уралдаан, тэмцээн, хурал, уулзалт, ярилцлагын хэлбэрээр түрээслүүлнэ.

5.4. Театр нь эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ худалдаж авахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийг баримтална.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Театрын дарга, уран бүтээлч, ажилтан, албан хаагчид хөдөлмөрийн өрээзгэр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Театрын дарга, уран бүтээлч, ажилтан албан хаагчид эрх хэмжээгээ хэтрүүлж, хууль тогтоомж зөрчсөн тухай иргэд байгууллагаас мэдээлэл ирж, гомдол гаргасан тохиолдолд холбогдох газруудад шилжүүлж, зохих журмын дагуу шийдвэрлүүлнэ.



ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

7.1.Байгууллагын дүрэм, дотоод журамд тусгагдсанаас бусад асуудлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар зохицуулна.

7.2.Энэхүү дүрэм нь Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, мердөгднө.

7.3.Энэхүү дүрэмд эрх бүхий этгээдийн саналыг үндэслэн, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлт нь дүрмийн салшгүй нэг хэсэг байна.

7.4.Дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

